



## “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

(2024 оны жилийн эцэс)

2024.12.25

### НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж байна.

### ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 8 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **91.25 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 8 арга хэмжээнээс хэрэгжилт 100 хувьтай 3 арга хэмжээ, 90 хувьтай 4 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төсөл арга хэмжээ, шалгуур үзүүлэлт тус бүрээр харуулбал:

| №   | Төсөл арга хэмжээ   | Шалгуур үзүүлэлт              | Хэрэгжилт   | Хувь |
|---|---|-------------------------------|---|------|
| <b>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Эдийн засаг бүлгийн хүрээнд:</b> |   |                               |   |      |
| <b>Тэргүүлэх чиглэл 2. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>  |   |                               |   |      |
| 1   | 2.3.2.17. БНПУ-н зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг | Барилгын ажлын гүйцэтгэл -70% | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс зэрэг 4 аймгийн төвийн суманд бохир ус цэвэрлэх байгууламж шинэчлэх, шинээр барих ажлын барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн ажил 2024 оны жилийн эцсийн байдлаар 48-74 хувийн | 70   |

|   |  |                                     |  |     |
|---|--|-------------------------------------|--|-----|
|   | үргэлжлүүлэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс/   |                                     | гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Дундаж хэрэгжилт 71 хувьтай байна.   |     |
| <b>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Бүс, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд:</b>  |  |                                     |  |     |
| <b>Тэргүүлэх чиглэл 5. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.</b>   |  |                                     |  |     |
| 2   | 5.1.1.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад УТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих    | Дэд бүтэц байгуулаг д-сан байршил-5 | Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүлэмж-агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр "Агро-сити" эдийн засгийн тусгай бүс /9000 га/, олон улсын тээвэр ложистик, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлэх зорилгоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүс /5650 га/ байгуулах асуудлыг 2024.5.22-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж дэмжигдсэн.<br>"Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" зураг төслийг 2024.5.30-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Төсөлд эксперт хийх орон тооны бус экспертүүдийн ажлын хэсгийг БХБС-ын 2024.6.24-ны өдрийн 114 дүгээр тушаалаар байгуулан магадлал хийгдэж байна.<br>Төлөвлөлтөөр паркийн 160 га газарт хэрэгжих төслийн эхний үе шат 2024-2039 он хүртэл, дараагийн үе шат нь 2040-2054 он хүртэлх хэрэгжихээр төлөвлөсөн байна. Тус яамны хариуцах асуудлын хүрээнд ажлыг цаг тухай бүрт нь хэрэгжилтийг хангаж ажилласан. | 90  |
| <b>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Улаанбаатар ба дагуул хот бүлгийн хүрээнд:</b> |  |                                     |  |     |
| <b>Тэргүүлэх чиглэл 6. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.</b>                                |  |                                     |  |     |
| 3   | 6.2.1.1."Залуус-1" төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл -50%       | <ul style="list-style-type: none"> <li>• Залуус-1 төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний 300м дулаан хангамжийн шугам сүлжээг өргөтгөсөн.</li> <li>• Дулаан хангамжийн шугамын нэвтрэх сувгийн /лотки/ 100 хувь, 1900 м шугам хоолойн угсралт хийгдэхээс 1750 м шугамын угсралт хийгдсэн.</li> <li>• Ус дулаан дамжуулах төвийн угсралт 80 хувь, дулааны үзлэгийн худаг 13 хийгдэхээс 10 хийгдсэн байна.</li> <li>• Холбогдох техникийн нөхцөл болон барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг нийслэлийн холбогдох газраас гаргуулсан.</li> <li>• Шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэхэд авто замтай огтлолцох хэсэгт авто зам сэтлэх зөвшөөрлийг Нийслэлийн замын хөгжлийн газраас зөвшөөрөл авахаар холбогдох материал бүрдүүлж хүргүүлсэн.</li> <li>• "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн цахилгаан хангамжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ гүйцэтгэгчээр "Би Эс Би Энерги" ХХК шалгарч ХТП 2х630 кВА чадалтай дэд өртөөний тоноглол, хувиарлах байгууламжийн тоноглолын ажлыг гүйцэтгэж байна.</li> </ul>  | 100 |
| 4   | 6.2.1.2."Ногоон нуур 1008" төслийн барилга   | Барилгын ажлын                      | 1. Орон сууцны барилга, сургууль, цэцэрлэгийн гадна хэрэгцээний цэвэр усны шугамын угсралтын ажлыг   | 90  |

|   |  |                               |  |     |
|---|--|-------------------------------|--|-----|
|   | угсралтын ажлыг үргэлжлүүлж, инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх   | гүйцэтгэл -100%               | гүйцэтгэж, холболтын гэрээ болон үндсэн гэрээг Ус сувгийн удирдах газартай байгуулсан.<br>2. Гадна фасадны кронштейн, металл рам угсралт 90.0 хувь, дулаалгын эрдэст хөвөнгийн ажил 90 хувь, блокуудын 1-3-р давхарын гадна чулуун өнгөлгөөний ажил 7, 8-р блок дээр хийгдэж байна.<br>3. 1-8-р блокуудын төмөр бетон хийцийн ажил бүрэн дуусаж барилгын цонх суурилуулалтын ажил 90.0 хувьтай хийгдэж байна.<br>4. 1-8-р блок барилга болон гаражийн дотор салхивчийн шугамын угсралтын ажил хийгдэж байна. Дотор хэрэгцээний халуун, хүйтэн усны шугамын угсралт 45 хувьтай, галын ердийн системийн хоолойн угсралт 80 хувьтай, бороо ус зайлуулах шугамын угсралт 80 хувьтай гүйцэтгэж байна.<br>5. 1-8-р блок барилгын подьёмын бетон цутгалт бүрэн явагдаж, подьём угсралтын ажил бүрэн хийгдэж ашиглагдаж байна.<br>6. Цахилгааны дэд өртөө улсын комиссийн дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулж Дэд өртөө-2-оос гараж руу кабель шугам татах ажил хийгдсэн.<br>7. Загварын өрөөг 3, 6-р блокуудын 3-р давхарт сонгон дотор заслын ажлыг гүйцэтгэж байна.<br>-2024 онд нийт 5 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан. Нийт 75,545,736,1 юанийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан.<br>Төслийн хэрэгжилт 2024.12.06-ны байдлаар 75 хувьтай хэрэгжиж байна. |     |
| 5 | 6.2.1.3."Солонго 1, 2" төслийн барилгын ажлыг эхлүүлэх   | Барилгын ажлын гүйцэтгэл -10% | Солонго-1, Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл"-ын барилга барих бэлтгэл ажил 2024.03.01-ний өдрөөс эхлэж, 2024.04.18-ны барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл гарсан.18 блок барилгын төмөр бетон каркас цутгалтын ажил бүрэн дуусч, 5 блок 9 давхар, 12 блок 8 давхрын каркас цутгалтын ажил гүйцэтгэж, 2 дугаар ээлжийн 31 блок барилгаас энэ жил 16 блок барилгын суурийн ул бетон хийж үүнээс 11 барилгын суурийн бетон цутгалт, нэгдсэн гражийн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажил төслийн хэмжээнд 35 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.  | 100 |
| 6 | 6.2.2.1. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх /Чингэлтэй, Сонгинохайрхан/ | Арга хэмжээний хэрэгжилт -38% | Улаанбаатар хотын гэр хорооллын Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад дэд төвүүдийг шинээр барихаар нийт 79 ажил төлөвлөн 2024 онд 6 төсөл хэрэгжүүлж байна.<br>Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдийн нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын зураг төсөл боловсруулах ажлын явц 100 хувь;<br>Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 96.7 хувь;<br>Худалдан авах ажиллагааны явц 77 хувь, нийт ажлын явц 39.5 хувьтай;<br>Дамбадаржаа дэд төвд: Ариутгах татуургын 3 км, ус хангамжийн 2.3 км, дулаан хангамжийн 2.2 км шугам сүлжээ, авто замын 2.8 км ажлын барилгын ажлын явц 66 хувь,<br>- 1.7 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын явц 100 хувь;<br>- Цахилгаан хангамжийн 2.8 км, холбооны сувагчлал 5.9 км, мэдээлэл холбооны төвийн багц барилгын ажлын явц 23 хувь,   | 90  |

|   |   |                                  |  |              |
|---|---|----------------------------------|--|--------------|
|   |   |                                  | <p>- 63 МВт дулааны станцын барилгын ажлын явц 6 хувь<br/>- 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явц 65 хувь.</p> <p>Шархад, Толгойт дэд төвүүдийн барилга угсралтын ажлын 35 хувьтай байна.</p> <p>Толгойт дэд төвийн 1.8 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын явц 85 хувь;</p> <p>- үерийн хамгааллын суваг 5.2 км ажлын барилгын ажлын явц 85 хувь,</p> <p>- сургалтын төвийн ажлын явц 90 хувь;</p> <p>- 6 км авто зам, 5.9км дулааны шугам, 7.7км цэвэр усны шугам, 8.8 км бохир усны шугамын худалдан авалт зохион байгуулагдаж байна.</p> <p>Нийт хэрэгжилт 35 хувьтай байна.</p>  |              |
| 7   | 6.2.3.2."Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төслийг үргэлжлүүлэх /инженерийн байгууламж/ | Дэд бүтцийн бүтээн байгуулалт-10 | <p>"Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2х10000кВА чадалтай "Хөндий" дэд станц, 110/35/10кВ-ын "Зуунмод" дэд станцын өргөтгөл /Төв/, Дэд станцын барилга тоноглолтой, 35кВ ил хуваарилах байгууламж тоноглолтой, нийт 105 ширхэг анкер цахилгаан дамжуулах агаарын шугам 15,7км хийгдсэн. Барилга угсралтын ажил 100 хувь дуусаж улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.</p> <p>"Үерийн хамгаалалтын суваг - 4 /4.9 км"-ийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд барилга байгууламж 2024.11.04-ний ББКД-79/2024 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад орсон.</p> <p>"Шинэ Зуунмод" хотын ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/- ажлын хүрээнд ус хангамжийн 2 дамжуулах Ф280х25.4 мм-ийн голчтой 3,756 км шугам, Эдийн засгийн чөлөөт бүсээс 1-15 худаг хүртлэх 2,69 км шугам, гол шугамын 1-р хэсгийн 4,83 км шугамын ажлыг гүйцэтгэж, 2024.12.06-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Ажлын явц нийт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> | 100          |
| <b>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Ногоон хөгжил бүлгийн хүрээнд:</b> |   |                                  |  |              |
| <b>Тэргүүлэх чиглэл 8. Ногоон хөгжлийг дэмжинэ.</b>   |   |                                  |  |              |
| 8   | 8.1.2.3. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих  | Төслийн ажлын гүйцэтгэл 90%      | <p>Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн технологийн 9, бусад 8, нийт 17 байгууламжийн барилга угсралтын ажил 66 хувьтай хэрэгжиж байна. Үүнээс 5 байгууламж буюу хүлээн авах худаг 100 хувь, шахуургын 1-р станц 53 хувь, тогтворжуулах сан 73.1 хувь, хөдөлгөөнт био реактор 54,4 хувь, ламелла тунгаагуурын байгууламжийн барилгын ажлын явц 51 хувийн гүйцэтгэлтэй байна. Үлдсэн 3 технологийн байгууламжаас ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилгын ажил 27 хувь, халдваргүйжүүлэх сан 73 хувь, шахуургын 2-р станц 49 хувь, ус зайлуулах сан 51 хувийн гүйцэтгэлтэй.</p> <p>Ус дамжуулах системийн хувьд төслийн нийт барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.</p>   | 90           |
| <b>Хэрэгжилт</b>  |   |                                  |  | <b>91.25</b> |



## Дараах үр дүнтэй арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэн ажилласан байна.

### Үүнд:

Солонго-1, Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл"-ын барилга барих бэлтгэл ажил 2024.03.01-ний өдрөөс эхэлж 18 блок барилгын төмөр бетон каркас цутгалтын ажил бүрэн дуусч, 5 блок 9 давхар, 12 блок 8 давхрын каркас цутгалтын ажил гүйцэтгэж, 2 дугаар ээлжийн 31 блок барилгаас энэ жил 16 блок барилгын суурийн ул бетон хийж үүнээс 11 барилгын суурийн бетон цутгалт, нэгдсэн гражийн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажил төслийн хэмжээнд 35 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. /Зорилтот түвшин 10 хувь/

"Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төслийн хүрээнд цахилгаан хангамж, ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний барилга угсралтын ажил комисс ажиллахад бэлэн болсон. "Үерийн хамгаалалтын суваг - 4 /4.9 км/"-ийн барилга байгууламж 2024.11.04-ний ББҚД-79/2024 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад орсон.

### ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 8 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **91.25 хувь**, "**тодорхой үр дүнд хүрсэн**" гэж дүгнэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах хүрээнд захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, бусад төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхэд жилийн эцсийн байдлаар Улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар 379,084.71 сая төгрөг зарцуулсан байна.

### ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Бүх газар хэлтэст зөвлөмж болгох нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан тус яамны эрхлэх асуудлын хүрээний энэ жилийн зорилтот түвшинд хүрсэн боловч бүрэн хэрэгжиж дуусаагүй арга хэмжээг 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, бүрэн хэрэгжүүлж дуусгах, амжилттай хэрэгжсэн төсөл арга хэмжээнд үндэслэн төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан, уялдаатай хэрэгжүүлж болох арга хэмжээний саналыг боловсруулж төлөвлөгөөндөө тусган ажиллах;

2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ буюу богино хугацааны бодлогын баримт бичгийн тухайн жилийн зорилтот түвшинд хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, хэрэгжилт, хяналтыг сайжруулан төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх;



3. Цаашид төлөвлөлтийг сайжруулах, суурь судалгаанд үндэслэх, шалгуур үзүүлэлтийг тоо болон чанарын үзүүлэлтээр, хүрэх түвшинг үр дүнд чиглэсэн, хэмжигдэхүйц, биелэх боломжтой, тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тодорхой хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байхаар тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх боломжтойгоор, үр дүнд хүрэх төлөвлөгөөг боловсруулахад анхаарч ажиллах;

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

4. Бүгд Найрамдах Польш Улсын зээлээр 5 аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийн нэгж Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж магадлалын дүгнэлтээр баталгаажуулан, төслийг төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оруулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР